



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 4/664

Хэрлэн сум


Арга хэмжээний зардалд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, 17.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 27 дугаар хуралдааны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/623 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн 2024 “Оны онцлох хүүхэд”-үүдийг алдаршуулах арга хэмжээний зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний Хүүхдэд ээлтэй орон нутаг болно зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ